

### 13. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх

59. “Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй” гэсэн Үндсэн хуулийн заалтаар иргэд болон хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл нээлттэй байхаар хуульчилсан. Цаашлаад хэвлэн нийтлэх эрхийг баталгаажуулах үүднээс УИХ-аас 1998 онд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг баталж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль гаргах, төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт тавихыг хориглосон. Үүнээс гадна 2005 онд Олон нийтийн радио, телевизийн тухай хуулиар төрийн мэдэлд байсан үндэсний радио, телевизийг олон нийтийн радио телевиз болгон өөрчлөх эрх зүйн үндсэн зохицуулалтыг хийсэн. Үүгээр уг телевиз олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээдэг, хяналтан дор нь үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус хуулийн этгээд болсон бөгөөд мөн үйл ажиллагаанд нь аливаа этгээд (хувь хүн, албан тушаалтан, байгууллага гэх мэт) хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглосон нь үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхийг хангахад чухал түлхэц болсон.

60. Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай харилцааг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Садар самуунтай тэмцэх тухай хуулиудаар тус тус зохицуулж байна.

61. Тайван замаар жагсаал, цуглаан хийх эрхийн хэрэгжилтийн талаар ХЭҮК-оос гаргадаг Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай 2004 оны илтгэлд оруулж, “цуглаан” гэсэн ойлголтыг тодорхойлох, зөвшөөрлийн тогтолцоо, зөвшөөрөл олгох хугацаа, субъектын талаарх зохицуулалтыг хянан үзэж, 2005 оны 11 дүгээр сард УИХ-аас Жагсаал, цуглаан хийх журмын тухай 1994 оны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж гудамж, талбайд жагсаал цуглаан зохион байгуулахад зөвшөөрөл олгодог хуулийн зохицуулалтыг бүртгэлийн зохицуулалттай болгосон.

62. 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр тогтоосон онц байдлын үеэр нийгмийн эмх замбараагүй байдал бий болж, дөрвөн иргэн галт зэвсгийн суманд өртөж, нэг хүн угаартаж нас барсан хэрэг гарсан. Галт зэвсгийн суманд дөрвөн иргэн өртөж нас барсан хэргийг Улсын Ерөнхий Прокурор (Цаашид “УЕП” гэх)-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба шалгаж Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлд заасан хүнийг санаатай алах гэмт хэрэгт зургаан албан хаагчийг холбогдуулан мөрдөн байцаалт явуулж гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр, албан тушаалын гэмт хэрэгт холбогдуулан шалгасан цагдаагийн дөрвөн удирдах ажилтныг Монгол Улсын Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу 2010 оны 2 дугаар сарын 3-ны өдөр тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Нэг хүн угаартаж нас барсан хэрэгт хууль бус жагсаал, цуглаан, нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулж, өдөөн түрхирсан зарим нам, хөдөлгөөний тэргүүнүүдэд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаад 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Монгол Улсын Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.